



ТАРАГТ СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМ-д

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2020.07.28 № 306  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.3, 37.5 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох тус сумын Монгол Ардын намаас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Монгол Ардын нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцүүлэн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт аймаг дахь Төрийн аудитын байгууллагад ирүүлж, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль 37 дугаар зүйлийн 37.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020” Тулгуур зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020”, Өвөрхангай аймгийн нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, “Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг”, Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

015030593

## Дүгнэлт

Сумын Монгол Ардын намын “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгууль”-д оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын заалт, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр / .... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сумын сонгуулийн хороонд

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.ЛАМААЧИН

# **ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ТАРАГТ СУМ**

**Тарагт сумын Монгол Ардын Намын Хороо**


**2020 оны сумын иргэдийн төлөөлөгчдийн**

**хурлын сонгуульд оролцох**

**“Хөгжлийн төлөө Тарагтчууд”**

**мөрийн хөтөлбөр**

**2020 он**



## 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ТАРАГТ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМААС ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

### 1. Эдийн засгийн өсөлт-Ажил, орлоготой иргэн

#### 1.1 Үйлдвэрлэл-хөгжлийн гарц

- 1.1.1 Мал аж ахуйн түүхий эдэд түшиглэсэн арьс, шир, ноос, ноолуурыг уламжлалт технологи болон бага оврын тоног төхөөрөмж ашиглан боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг цех байгуулах.
- 1.1.2 Сүү боловсруулах цех байгуулж, малчид иргэдийн сүү, цагаан идээ боловруулж аймаг хотын зах зээлд гаргах идэвхийг дэмжиж ажиллана.
- 1.1.3 Түүхий эд хүлээн авах төвлөрсөн цэгтэй болох, хоёрдогч түүхий эд боловсруулах жижиг үйлдвэртэй болох.
- 1.1.4 Талх, нарийн боовны цехтэй болох үйл ажиллагааг өргөжүүлэх.
- 1.1.5 Өрхийн тариаланг хөгжүүлж, техник тоног төхөөрөмжөөр хангах.

#### 1.2 Орон нутгийн хөгжил сумаас эхэлнэ

- 1.2.1 Сумын төвийг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хот байгуулалтын инженерийн шугам сүлжээ, авто болон явган хүний зам, замын гэрэлтүүлэг, ногоон байгууламж, үерийн суваг, гэр хорооллуудын гудамж талбайн хэсэгчилсэн төлөвлөлтүүдийг сумын онцлогт тохируулан боловсруулж үе шаттай хэрэгжүүлнэ.
- 1.2.2 Сумыг төвлөрсөн инженерийн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжтай болгоно.

#### 1.3 Хот байгуулалт, дэд бүтэц

- 1.3.1 Тарагт сумын төвд “Ахуйн үйлчилгээний нэгдсэн төв”-тэй болох
- 1.3.2 Тарагт сумын ерөнхий боловсролын сургуулийг орчин үеийн шаардлага нийцсэн спорт заалтай болгох
- 1.3.3 Тарагт суманд “Ахмадын өргөө” шинээр барьж үйл ажиллагааг өргөжүүлнэ.
- 1.3.4 Тарагт сумын сургуулийн өмнөх боловсролын байгууллагат өргөтгөл хийж урлаг заалтай болгох
- 1.3.5 Тарагт сумын Туяа 1-р багийн бага сургуулийг түшиглэн спорт заалтай болгох.

Two handwritten signatures and initials are present at the bottom right of the page.

1.3.6 Тарагт суманд үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудыг нэгдсэн байраар хангах.

#### **1.4 Хүнс Хөдөө аж ахуй, Хөдөлмөр эрхлэлт**

1.4.1 Мал, амьтны гаралтай халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах замаар мал, амьтны гоц халдварт өвчингүй тайван бүс болгох.

1.4.2 Фермүүдийг хөгжүүлэхтэй холбогдуулан тэжээл үйлдвэрлэлд шинэ техник, технологи нэвтрүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, өвс, тэжээлийн нөөцийн сан, тэжээлийн цех байгуулах.

1.4.3 Бэлчээрийг бордох, олон наст ургамал тариалах, хашиж хамгаалах зэргээр бэлчээрийн ашиглалтын менежментийг сайжруулах, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, инженерийн хийцтэй худаг шинээр барих, засварлах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлнэ.

1.4.4 Цөөн малтай, мал маллах сонирхолтой малчин бус өрх болон залуучуудыг төсөл хөтөлбөрт хамруулах.

1.4.5 Нөхөрлөл хоршоо, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих бодлого боловсруулан хэрэгжүүлэх.

1.4.6 Газар тариалан хүнсний ногоо, жимс жимсгэн, төрөлжсөн зоорь, өвлийн хүлэмжийн аж ахуй, малын тэжээл зэргийн тариалалтыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч дэмжиж ажиллана.

1.4.7 Эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих орон нутгийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх.

#### **1.5 Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхай**

1.5.1 Уул уурхайн улмаас эвдэрсэн газар талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хийж хамгаалалтанд авна.

1.5.2 Аялал жуулчлалыг хөгжүүлж байгалийн болон түүх, соёлын дурсгалт газар, Хүрэмт халуун рашаан амралт сувилал зэрэг газруудыг аялал жуулчлалын маршрутад хамруулж дэмжин ажиллана.

### **2. Нийгмийн бодлого-Хүний хөгжил**

#### **2.1 Эрүүл иргэн-Нийгмийн үнэт баялаг**

2.1.1 Эрүүл мэндийн төв, багийн эмчийг шаардлагатай эмчилгээ, оношлогооны тоног төхөөрөмжөөр хангаж иргэдийг эрүүл мэндийн үйлчилгээнд жил бүр үнэ төлбөргүй хамруулна.

#### **2.2 Боловсрол төлөвшил-хүний үнэт зүйл**

2.2.1 Тарагт сумын Туяа багийн бага сургуулийг түшиглэн сургуулийн өмнөх боловсролын бэлтгэл анги нээх.



- 2.2.2 Иргэдэд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээг зайны болон нүүдлийн хэлбэрт оруулан, хөгжим, бүжгийн мэргэжлийн багшаар бүрэн хангаж соёлын үйлчилгээг сайжруулна.
- 2.2.3 Залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд анхаарч залуучуудын ТББ-ыг дэмжин ажиллана.
- 2.2.4 Спортын бүх төрлийг дэмжиж ажиллана.
- 2.2.5 Орон нутгийн судлах музей, номын сангийн үйлчилгээг сайжруулж үзмэр, номын фондыг нэмэгдүүлнэ.

### **3. Иргэдийн оролцоотой төрийн үйлчилгээ**


#### **3.1 Төрийн үйлчилгээ иргэн танд**

- 3.1.1 Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, илүү нээлттэй байлгах үүднээс чадварлаг боловсон хүчнээр хангаж ажиллана.
- 3.1.2 Төрийн албан хаагч буюу сумын иргэдийг тохилог орон сууцаар хангах.
- 3.1.3 Иргэд, олон нийтийн оролцоотойгоор газар зохион байгуулалт, төлөвлөлтийн үйл ажиллагааг нээлттэй ил тодоор хуулийн дагуу хэрэгжүүлэх.

#### **3.2. Хууль эрх зүй, аюулгүй амьдрал**

- 3.2.1 Ард иргэдийн амар тайван амьдрах орчныг бүрдүүлнэ.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТАРАГТ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО



  23